



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амар даатгал” ХХК-ийн “Эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Олон улсын эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Ард даатгал” ХХК /Т.Батзул/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 01 сарын 15 өдрийн  
1/1 –р тогтоолын нэгдүгээр хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Амар даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Эрүүл мэндийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	-Хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд -Байгууллагын ажиллагсад болон группын гишүүдийн эрүүл мэнд
5.	Даатгалын эрсдэл	Бүх төрлийн гэнэтийн осол болон ердийн өвчлөл
6.	Даатгалын гэрээний хугацаа	Нэг жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 280 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Амар даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэр.
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Уранцэцэг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Бизнес хөгжлийн газрын захирал Т.Тэлмэн, Үйл ажиллагааны газрын захирал Я.Энхбаяр, Ерөнхий менежер Н.Мөнх-Эрдэнэ, Хуулийн зөвлөх Г.Энхцэцэг, Даатгалын менежер Э.Хулангаа

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 01 сарын 08 өдрийн  
11-р тогтоолын хоёрдугаар хавсралт

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Амар даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Олон улсын эрүүл мэндийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	Үндсэн даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндтэй холбоотой ашиг сонирхол
5.	Даатгалын эрсдэл	Бүх төрлийн гэнэтийн осол болон ердийн өвчлөл
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 271 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Амар даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэр.
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Уранцэцэг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Бизнес хөгжлийн газрын захирал Т.Тэлмэн, Үйл ажиллагааны газрын захирал Я.Энхбаяр, Ерөнхий менежер Н.Мөнх-Эрдэнэ, Хуулийн зөвлөх Т.Билгүүн, Даатгалын менежер Э.Хулангаа